хүний био давтамжаар тодорхойлдог ба үнэний магадлал нь 98 хувьтай байдаг. Энэ аппаратыг ажиллуулахад зөөврийн компьютер (notebook) шаардлагатай, хэрэглээний программын мэдлэгтэй хүн ажиллуулах бүрэн боломжтой. Дүгнэлт:

1. Мансууруулах болон сэтгэц идэвхит эм, бодисын хууль бус эргэлттэй холбоотой бүхий л асуудлыг багтаасан хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох хариуцлагын тогтолцоог чангатгах;

2. Мансууруулах бодистой тэмцэх хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах;

3. Мэргэшсэн алба, хүний нөөц бий болгох, дагнасан судалгаа явуулах болон энэ төрлийн гэмт хэргий урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох онол, арга зүйг боловсруулах хэрэгцээ, шаардлага нь Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудын өмнө тулгарч байна.

*ХСИС-ийн Хууль сахиулахын удирдлагын*
*академийн 821 дүгээр дамжааны сонсогч,*
*цагдаагийн хошууч Х.Баатарцогт*

## МӨРДӨН БАЙЦААГЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХАД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

***Хураангуй.*** *Мөрдөн байцаагчийн аюулгүй байдлыг хангах ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, сайжруулах арга замыг бий болгоход оршино.*

***Түлхүүр үг.*** *Аюулгүй байдал, мөрдөн байцаагч, мөрдөн байцаагчийн аюулгүй байдал.*

Шүүх эрх мэдлийн байгууллага дотор эрүүгийн хэргийн нотлох баримтыг бүрдүүлэх хамгийн анхны бөгөөд хариуцлагатай үүргийг гүйцэтгэдэг албан тушаалтны нэг нь мөрдөн байцаагч бөгөөд түүний шударгаар, хараат бусаар ажиллахад аюулгүй байдлын ажиллагаа хамгийн чухал юм.

Мөрдөн байцаагчийн аюулгүй байдлыг хууль эрх зүйн аюулгүй байдал, үйл ажиллагааны аюулгүй байдал, бие, сэтгэл санааны аюулгүй байдал, эдийн засгийн аюулгүй байдал гэж ангилан судалсаны үндсэн дээр тулгамдаж буй асуудлыг тодорхойлох боломжтой юм.

Мөрдөн байцаагчийн аюулгүй байдлыг хамгаалж байгаа хууль эрх зүйн акт, тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн хоёр дахь хэсэгт эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхтэй, 4 дэх хэсэгт ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй. Хэнийг ч хууль

бусаар албадан хөделмөрлүүлж болохгүй. Хөдөлмөрийн тухай Монгол улсын хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт: Ажил олгогч нь ажилтныг түүний ажлын нөхцөл, ажил үүргийн онцлогт тохирсон ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр үнэ төлбөргүй хангах үүрэгтэй, 15.2. дах хэсэгт Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг турших, худалдаж авах, хадгалах, угааж цэвэрлэх, засварлах, ариутгах зардлыг ажил олгогч хариуцна.

Мөрдөн байцаагчийн үйл ажиллагаанд баримталж байгаа хууль эрх зүйн акт. Үүнд: Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Эрүүгийн хууль, Улсын Ерөнхий прокурорын 32 дугаартай тушаалаар батлагдсан Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны аргачилсан заавар, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам гэх мэт. Дээрх хоёр төрлийн хууль эрх зүйн актад судалгаа хийж үзэхэд мөрдөн байцаагчид үүрэг болгосон хэм хэмжээ нарийн тодорхой заагдсан байна. Харин мөрдөн байцаагчийн аюулгүй байдлыг хангах талаарх заалт байхгүй зөвхөн төрийн тусгай албан хаагч буюу цагдаагийн албан хаагч гэх нийтлэг нэрийн дор чухал эрх нь хангагдахгүй орхигдох тохиолдол байна. Дээрх хууль эрх зүйн аюулгүй байдлыг мөрдөн байцаагчийн аюулгүй байдалтай холбон авч үзье. Мөрдөн байцаагч нь хэрэг учралын газарт үзлэг хийх, сэжигтэн яллагдагч, гэрч хохирогчийн мэдүүлгийг газар дээр нь шалгах, туршилт хийх, таньж олуулах ажиллагаа явуулах зэрэг хууль тогтоомжинд заасан үүргээ хэрэгжүүлэхдээ байгаль цаг агаарын янз бүрийн нөхцөлд, улс орны өнцөг булан бүрийн төрөл бүрийн эрсдэлтэй аюултай газар, орчин обьектод өдөр шөнийн алинд нь ч өөрийнхөө аюулгүй байдлыг үл хайхран үйл ажиллагаагаа явуулсаар байна. 2016 онд ЦЕГ-ын Гэмт хэрэгтэй тэмцэх газраас нэг жижүүрийн мөрдөн байцаагчид хэргийн газрын үзлэгийн үед өмсөх хувцасны судалгаа тооцоог гаргахад материалын сайн муугаас шалтгаалж 52500-100000 төгрөгний зардал гарахаар тогтоогдсон бөгөөд зөвхөн Улаанбаатар хотын дүүрэг дэх цагдаагийн 14 хэлтсийн 56 жижүүрийн мөрдөн байцаагчийг хангахад 2.940.000-5.600.000 төгрөг зарцуулахаар болсон ч төсөвт, мөнгө байхгүй шалтгаанаар хувцасны асуудал шийдэгдээгүй байна. Энэ нь мөрдөн байцаагч ялзарч муудсан цогцос, гал түймрийн гэх мэт хувцас, биед үнэр нь шингэж арилахааргүй хэргийн газрын орчинд ажилласан хувцастайгаа 24 цагийн туршид ажиллаж, өөрийнхөө болоод хамт амьдарч ажиллаж байгаа бусад хүмүүсийнхээ эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах эрхийг хязгаарлан боогдуулж байгаагийн нэг хэлбэр юм.

Хөдөлмөрийн аюулгүй байдлыг тухай хууль, хөдөлмөрийн аюулгүй байдлын журамд дурьдсанаар хөдөлмөрийн нөхцөлийг тохиромжтой, зөвшөөрөгдсөн, хортой, аюултай гэж хуваажээ.

Мөрдөн байцаагч нь дээр дурьдсан 4 төрлийн аль нөхцөлд нь үйл ажиллагаагаа өдөр тутам явуулсаар байна. Зарим тохиолдолд хөдөлмөрийн тохиромжтой өрөөнд хүн байцааж сууж байхад, ялзарч муудсан цогцос, дулааны шугам шуудуу зэрэг хортой нөхцөлд хэргийн газрын үзлэг хийж, гал гарч шатсан хэзээ нурах нь тогтоогдоохгүй обьектод үзлэг хийх, сэтгэцийн өвчний учир гэмт хэрэг үйлдсэн нийгэмд аюултай хүнпйг урьдчилан мэдэх боломжгүйгээр тайлбар мэдүүлэг авах зэрэг хөдөлмөрийн аюултай нөхцөлд ажиллаж байна. Ингэж хөдөлмөрийн 4 өөр нөхцөлийн алинд ч хамааруулж болохгүйгээр өдөр тутам өөр нөхцөл байдалд ажиллаж байгаа нь мөрдөн байцаагчид аюултай байдлыг бий болгож байгаа юм.

Хэргийн газрын үзлэгийн хувцаснаас эхлээд мөрдөн шалгах ажиллагааны зардал болох гэрч, хохирогчийг дуудан ирүүлэх, бичгийн цаас, принтерийн хор, шинжилгээний, албан томилолт, автомашины шатахууны зэрэг мөрдөн байцаагчийн үйл ажиллагаагаа явуулахад гарч буй бүх зардлаас гадна, цалин хөлс, урамшуулал, тэтгэвэр тэтгэмжийн нөхцөл зэрэг нь мөрдөн байцаагчийн эдийн засгийн аюулгүй байдлыг тодорхойлно. Шүүгч, прокурорын цалин хөлснөөс гадна Тагнуулын Ерөнхий газар, Авилгалтай тэмцэх газрын мөрдөн байцаагчийн цалин хөлснөөс цагдаагийн байгууллагын мөрдөн байцаагчийн цалин хөлс доогуур байгаагаас авч үзэхэд эдийн засгийн аюулгүй байдал ямар түвшинд байгаа нь тодорхой харагдаж байна. Мөн мөрдөн байцаагч нь цогцостой ажилласан тохиолдол бүрт 15000 төгрөг, ялзарч муудсан цогцостой ажиллахад 20000 төгрөг нэмэгдлээр авахаар цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журамд зохицуулалттай хэдий ч төсөвт мөнгө байхгүй шалтгаанаар одоог хүртэл олгогдохгүй байна.

Мөрдөн байцаагчийн бие, сэтгэл санааны аюулгүй байдал нь ажиллаж амрах цагийг хөдөлмөрийн зүй зохистой хуваарийн дагуу хэрэглэх нөхцөл боломж, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх, амралт чөлөөт цагийг бий болгон спорт биеийн тамираар хичээллэх зэргээр зүй зохистой өнгөрүүлэх, архи тамхи гэх мэт хорт зуршлаас сэргийлэх, үйл ажиллагаа явуулж байхдаа болон явуулсантай холбогдуулан гэмт халдлагад өртөхөөс урьдчилан сэргийлсэн байдал, хөдөлмөрийн эрүүл аюулгүй орчинд ажиллах зэрэг нөхцөл боломжийг бүрэн хангаснаар алба хаагч, албаны үйл ажиллагааны чанар бүтээмж дээшилж мөрдөн байцаагчийн аюулгүй байдал хангагдана. Мөрдөн

байцаагч албан үүргээ гүйцэтгэж байгаад амь насаа алдсан, хүнд, хүндэвтэр, хөнгөн бэртэж гэмтсэн тохиолдол цөөнгүй байгаа боловч цагдаагийн байгууллагад тэдгээр хэрэг зөрчлийг бүртгэж шалтгаан нөхцлийг судалж, түүнийг арилгах чиглэлээр ажиллаж байгаа алба нэгж байхгүй байна.

Мөрдөн байцаагчийн сэтгэл санааны аюулгүй байдлыг хангахад гарч байгаа бэрхшээлийг дараах байдлаар тодорхойлъё. Үүнд:

- Гэмт хэрэгтэнтэй болон гэмт хэргийн улмаас хохирсон, түүнийг үзэж харсан гэрч зэрэг сэтгэл санааны хувьд цочирдсон хүмүүстэй өдөр тутам харьцаж тэдгээрээс гаргаж буй сэтгэлийн хөдөлгөөнийг мөрдөн байцаагч нь нүүр тулан харьцаж байгаа хүнийхээ хувьд шууд болон шууд бусаар хүлээн авдаг.
- Өөрт үүсч байгаа сэтгэл санааны бухимдал, стрессийг зөвөөр гаргах хувийн болоод албаны нөхцөл боломж бүрдээгүй.
- Хууль эрх зүй, гэмт хэрэг илрүүлэх чиглэлийн хичээлээр мэргэшүүлэн бэлтгэж байгаагаас өөр сэтгэл зүйн хувьд өөрт болон бусдад учирсан стресс, сэтгэл санааны дарамт, бухимдлыг хэрхэн гаргах талаар сэтгэл зүйн хичээл зааж сургадаггүй.
- Мөрдөн байцаагчаар ажиллах алба хаагчдаас полиграфын аппаратаар тест, сорилт авч байгаа нь ахицтай хэлбэр боловч түүний сэтгэл зүйн чадамж чадвартай холбоотой сорилт авч үр дүнг нь ашиглахгүй байгаа гэх мэт шалтгаан нөхцөл байна.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журамд сэтгэл зүйчийн ажиллах үндэслэл журмыг тодорхойлж өгсөн нь чухал ач холбогдолтой боловч бодит байдал дээр хэрэгжихгүй байна. Тухайлбал: Цогцостой ажилласан мөрдөн байцаагчид сэтгэл зүйн эмчилгээ хийж байх талаар тусгсан хэдий ч мөрдөн байцаагч хувь хүний болоод албаны удирдлага зохион байгуулалтын буруугаас болоод энэ хэрэгжихгүй байна.

2015 онд цагдаагийн байгууллагад нийт 397 мөрдөн байцаагч ажиллаж 29035 эрүүгийн хэрэг, 35186 өргөдөл гомдол хүлээн авч шалгасан нь нэг мөрдөн байцаагч дунджаар 76.4 эрүүгийн хэрэг, 92.5 өргөдөл, гомдол шалгасан ажлын дүн мэдээ гарсан байна. 2015 оны эхний 7 сарын байдлаар цагдаагийн байгууллагын мөрдөн байцаах албанд ирсэн прокурорын 107 шаардлагад судалгаа хийж шалтгаан нөхцлийг тогтооход 75.5 хувь нь хэрэг материалын хугацаа хэтэрсэн, хуулийн хугацаанд сунгагдаагүй, 17.3 хувь нь прокурорын хэрэгт бичсэн даалгаврыг биелүүлээгүй, дутуу биелүүлсэн, 6.2 хувь бусад үндэслэлээр хууль зөрчсөн тухай заагдаж, зөрчил гаргасан мөрдөн байцаагч нарт сахилгын арга хэмжээ, үр дүнгийн хувиар арга хэмжээ тооцсон байна. Энэ нь

мөрдөн байцаагчийн ажлын ачаалал их байгаагаас шалтгаалж байгаа тул хөдөлмөрийн зохион байгуулалтыг сайжруулах, орон тоог нэмэгдүүлж ажиллах шаардлагатай байна. Цагдаагийн ерөнхий газрын хэмжээнд хохирсон алба хаагчдын талаарх судалгаа явуулахад 1,1 өдөрт нэг цагдаагийн алба хаагч ямар нэг төрлийн гэмт хэрэг, зөрчлийн хохирогч болж байна. 2011-2014, 2015 оны эхний 8 сарын байдлаар албан үүргээ гүйцэтгэж байхдаа Эрүүгийн хуулийн 16 зүйлээр 433 гэмт хэрэгт хохирсон буюу 4 өдөр тутам нэг цагдаагийн алба хаагч гэмт хэргийн хохирогч болж байна гэсэн судалгаа гарсан байна.

Уг судалгаанд Эрүүгийн хуулийн 230-р зүйлд *(төрийн албан хаагчийг эсэргүүцэх)* зааснаар 261 гэмт хэрэг бүртгэгдсэн нь нийт гэмт хэргийн 43,3 хувийг, албан үүрэгтэй холбоотой нийт гэмт хэргийн 60.3 хувийг эзэлсэн байна. Нийт санал асуулгад оролцогчдын 1545 буюу 61% нь доромжлуулах, 1459 буюу 57% нь гүтгүүлэх, 1401 буюу 55% нь хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх, заналхийлэх нь хамгийн их тохиолддог буюу “өндөр эрсдэлтэй” болон “эрсдэлтэй” гэж тодорхойлсон байна.

Энэ судалгаанаас үзэхэд цагдаагийн алба хаагчийн аюулгүй байдлыг хангаж байгаа өнөөгийн байдал учир дутагдалтай болох нь харагдаж байна. Энэ нь цагдаагийн байгууллага нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах өндөр их үүрэг хариуцлагатай ажлын ачааллаас болж алба хаагчдын аюулгүй байдлыг хангах ажил орхигдсон, зарим нэг ажлууд хийгдэж байгаа боловч төдийлэн үр дүнд хүрэхгүй байгаа нь алба хаагч бүрийг ажил мэргэжлээр нь ангилан хуваан авч үзэж тэдгээрт үүсэх эрсдлийг тодорхойлж тогтоогоогүй буюу хувь хүний аюулгүй байдлыг хангах чиглэлээр ажил хийдэггүйтэй холбоотой гэж үзэж байна. Иймд мөрдөн байцаагчийн дээр дурьдсан аюулгүй байдлыг чиглэл бүрээр нь хангаж ажиллахын тулд дараах саналыг гаргаж байна. Үүнд:

Мөрдөн байцаагчийн аюулгүй байдлыг хангах талаар ЦЕГ-аас нэгдсэн бодлого, төлөвлөгөө гарган ажиллах. Мөрдөн шгалгах ажиллагааны зардлыг төсөвт заавал суулгуулан түүнийг зориулалтын дагуу зарцуулах. Мөрдөн шалгах ажиллагаа явуулахад баримтлах аюулгүй ажиллагааны заавар журмыг мөрдөн байцаагчийн өдөр тутам явуулдаг ажиллагаа бүр дээр боловсруулж, батлан мөрдүүлэх. Түүнд зарцуулах төсөв хөрөнгийг байгууллагын төсөвт суулгуулах. Мөрдөн байцаагчийн аюулгүй байдлыг хариуцсан алба, нэгж ажилтанг бий болгож гэмт хэрэг, зөрчлийн улмаас хохирсон мөрдөн байцаагчдын судалгааг үнэн бодитой гаргаж шалтгаан нөхцлийг тогтоон түүний дагуу ажилладаг байх г санал гаргаж байна.